



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/197

Хэрлэн сум

Сургалт зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05, 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.4 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн тогоочдыг эрүүл ахуйн зохистой дадал мөрдүүлэх сургалт хийхэд зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын 16 -ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОГООЧДЫГ ЭРҮҮЛ АХУЙН
ЗОХИСТОЙ ДАДАЛ МӨРДҮҮЛЭХ СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үнэ	
				Нэгж мян/төг	Бүгд үнэ Мян/ төг
1	Бичиг хэргийн зардал	Боодол	20	22000	440000
2	Шатахууны зардал	Литр	640	2550	1632000
3	Гарын авлага	Ширхэг	290	3200	928000
Нийт дүн:					3,000,000